



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар A/410

Улаанбаатар хот

### Байгууллагын стандарт батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрэн хайх, аврах ажиллагаа ОББС 0001:2018” стандартыг баталсугай.
2. Энэхүү стандартыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

ДАРГА  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ





---

**БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ**

**Эрэн хайх, аврах ажиллагаа**

**ОББС 0001:2018**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Улаанбаатар хот  
2018 он**

**Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)**

Шуудангийн хаяг: Улаанбаатар хот-14250, Сүхбаатар дүүрэг, Партизаны гудамж,  
Утас: 976-51-263564, Факс: 976-11-324977  
E-mail: [doc@nema.mn](mailto:doc@nema.mn)

**© ОБЕГ, 2018**

---

“Гамшигаас хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг  
бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү ОБЕГ  
(Онцгой байдлын байгууллага)-т байна.

**ӨМНӨХ ҮГ**

Онцгой байдлын ерөнхий газар нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага юм.

Энэхүү стандартыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дахь хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн болно.

**ГАРЧИГ**

Д/д	Агуулга	Хуудасны дугаар
1.	Зорилго	1
2.	Хамрах хүрээ	1
3.	Норматив ишлэл	1
4.	Нэр томъёо, тодорхойлолт	2
5.	Товчилсон нэр томъёо	2
6.	Эрэн хайх, аврах ажиллагааны үе шат	2
7.	Эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага	2
8.	Эрэн хайх, аврах ажиллагааны зохион байгуулалт	4
9.	Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах хүч хэрэгсэл	5
10.	Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах хугацаа	5

## БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

<b>Эрэн хайх, аврах ажиллагаа</b> Search and rescue	<b>ОББС 0001 :2018</b>
--------------------------------------------------------	------------------------

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 04 -ний өдрийн 410 дугаар тушаалаар батлав.

Стандартыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Зорилго

Байгаль, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, ослын үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулахад баримтална.

### 2. Хамрах хүрээ

Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид хамаарна.

### 3. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

MNS 6345:2012, Аврагчдын хувцас, хэрэглэлд тавих ерөнхий шаардлага;

MNS 5620:2006, Амьсгалын замын аюулаас хамгаалах хэрэгсэл (хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг);

MNS 6347:2012, Биологи, цацраг, химиийн аврах ажиллагааны хувцас, хэрэглэлд тавих шаардлага;

MNS 6348:2012, Гал сөнөөгчийн хувцас. Ерөнхий техникийн шаардлагууд;

MNS 6010:2016, Гамшигийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт;

MNS 6412:2013, Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага;

MNS 0639:2016, Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо ба тодорхойлолт;

MNS 6349:2012, Гал сөнөөгчийн хамгаалах хэрэглэлд тавих ерөнхий шаардлага /Толгой, гар, хөл хамгаалах хэрэглэл, бус/;

MNS 6350:2012, Инженер сапёрын хувцас, хэрэглэлд тавих ерөнхий шаардлага;

MNS 6343:2012, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцасны ерөнхий ангилал, нэр төрөл, хэмжээ;

MNS 6344:2012, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын хувцсанд тавих ерөнхий шаардлага;

MNS 6455:2014, Хот суурин газарт хийх эрэн хайх, аврах ажиллагаа;

MNS NFPA 1670:2010, Эрэл хайгуул, аврах ажлын үйл ажиллагаа ба сургалт;

MNS 6346:2012, Уснаас аврах ажиллагааны хувцас, хэрэглэлд тавих шаардлага;

MNS 6352:2012, Уулын аврах ажиллагааны хувцас, хэрэглэлд тавих шаардлага.

MNS 6351:2012, Шүхэрчний хувцас, хэрэглэлд тавих ерөнхий шаардлага;

#### 4. Нэр томъёо, тодорхойлолт

##### 4.1.

###### **эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч**

Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний аврах бригад, бүсийн төв, аймаг, нийслэлийн  
Онцгой байдлын газар, хэлтсийг удирдах эрх бүхий мэргэшсэн алба хаагчийг;

##### 4.2.

###### **эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч**

Аврах анги, салбарыг удирдах эрх бүхий мэргэшсэн алба хаагчийг;

##### 4.3.

###### **эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч**

Аврах бүлгийг удирдах эрх бүхий мэргэшсэн алба хаагчийг;

##### 4.4.

###### **аврагч**

Эрэн хайх, аврах ажиллагаанд бэлтгэгдсэн эрх бүхий алба хаагчийг;

#### 5. Товчилсон нэр томъёо

5.1. АЕУ /Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч/

5.2. ААУ /Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч/

5.3. АУ /Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч/

5.4. А /Аврагч/

#### 6. Эрэн хайх, аврах ажиллагааны үе шат

6.1. Эрэн хайх, аврах ажиллагаа дараах үе шаттай байна. Үүнд:

6.1.1. мэдээлэл хүлээн авах;

6.1.2. голомтод хүрэлцэн очих;

6.1.3. төлөвлөх /цагийн байдлыг үнэлэх болон шийдвэр гаргах/;

6.1.4. шуурхай арга хэмжээг авах;

6.1.5. ажиллагааг дуусгах.

#### 7. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдлага

7.1. Эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагч:

7.1.1. эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх нэгжийн захирагч нарыг үүрэгжүүлэх;

7.1.2. эрэн хайх, аврах ажиллагааны төлөвлөгөөгөөр ажиллах бүрэлдэхүүнийг баталж, нутаг дэвсгэрийн байршил, газар зүйн онцлог, цар хүрээнээс хамаарч шаардагдах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.3. эрэн хайх, аврах ажиллагаанд зарцуулах хүнс, шатахууны нөөцийг бүрдүүлэх;

7.1.4. тухайн бүс, төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй болсон тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газар /шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч/-т мэдэгдэж зэргэлдээ орон нутгийн онцгой байдлын байгууллагатай харилцан ажиллаж хүч нэмэгдүүлэх;

7.1.5. Үндэсний аврах бригад болон орон нутгийн хүч нэмэгдүүлэн ажиллуулах асуудлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшигийн шуурхай удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга шийдвэрлэх.

7.2. Эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагч:

7.2.1. эрэн хайх, аврах бүлгүүдийг "Үндсэн", "Бэлтгэл", "Нэмэлт", "Нөөц" хэлбэрээр төлөвлөн зохион байгуулах;

7.2.2. эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах;

7.2.3. эрэн хайх, аврах ажиллагааны даалгаврын баримт бичгийн бүртгэл, техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн ашиглалт, ажиллах хугацаанд хяналт тавих;

7.2.4. хүч хэрэгсэл нэмэгдүүлэх, эгүүлэн татах, ээлж солих ажлыг зохион байгуулах;

7.2.5. эрэн хайх, аврах ажиллагааны үргэлжлэх хугацааг газар орны байршил, байгаль, цаг агаар, үүссэн нөхцөл байдлыг харгалзан харьяалах эрэн хайх, аврах ажиллагааны ерөнхий удирдагчтай зөвшилцөн шийдвэрлэх.

7.3. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч:

7.3.1. ослын голомтод эхний ирсэн аврах бүлгийн дарга эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч байна;

7.3.2. нисдэг тэрэг, нисэх төхөөрөмж ашиглахдаа нисгэгч болон нисэх төхөөрөмж хариуцагч техникч, мэргэжилтнийг шууд удирдлагадаа авах;

7.3.3. голомтод ажиллах төлөвлөгөө боловсруулах;

7.3.4. аврах бүлгийн бие бүрэлдэхүүний тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдалд үзлэг, шалгалт хийх;

7.3.5. аврагчдын аюулгүй байдалд хяналт тавих;

7.3.6. үүссэн цагийн байдалтай уялдуулж шаардлагатай хүч, хэрэгслээр хангах ажиллагааг зохион байгуулах;

7.3.7. шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагад хэргийн газарт үзлэг хийх боломжийг олгох;

7.3.8. нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх;

7.3.9. үүссэн цагийн байдал түүний явцад гарсан өөрчлөлтийг байр зүйн зурагт хөтлөх;

7.3.10. газар орны баримжаалал, хөдөлгөөний чиглэл, харилцах дохионууд, цугларах газар, хоорондын зайд ба хайгуулын талбайн хязгаарыг тогтоох;

7.3.11. нөхцөл байдлын талаарх үнэн бодит мэдээллээр харьяа газар, хэлтсийг тогтмол хангах;

7.3.12. эрэн хайх, аврах бүрэлдэхүүний хоноглох газар, байр, сууц, хоол хүнсийг хангуйсан байх, шаардлагатай тохиолдолд дээд шатны удирдлага болон сум, дүүргийн удирдлагаар шийдвэрлүүлэх;

7.3.13. эрэн хайх, аврах ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

7.3.14. шаардлагатай нөхцөлд хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг авах;

7.3.15. шаардлагатай тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон багаж, техник хэрэгслийг татан оролцуулах;

7.3.16. гэрчийн мэдүүлгээр нэрвэгдэгсийн байгаа газар, тэдгээрийн тоо, богино хугацаанд очих зам, чиглэл, биеийн байдал ямар байгаа, хоёрдогч аюултай хүчин зүйл байгаа эсэхийг асууж тодруулах;

7.3.17. шаардлагатай тохиолдолд мэдээлэл цуглуулах, баримтжуулах зорилгоор дуу хураагуур болон дурс бичлэг ашиглах;

7.3.18. буцалтгүй нэрвэгдэгч /амьд биш нэрвэгдэгч буюу хүний цогцос/-ийг эрэн хайж байгаа үед нэмэлт ослын дуудлага ирвэл эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр бүлгийн бүрэлдэхүүнийг бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлж эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх;

7.3.19. эрэн хайх, аврах ажиллагаа эхэлснээс хойш 72 цагийн дотор төөрсөн, сураггүй болсон иргэнийг олоогүй тохиолдолд ар гэрийнхэн болон эрэн хайх, аврах ажиллагааны ахлах удирдагчтай зөвшилцөн үргэлжлүүлэх, хойшлуулах эсхүл зогсоох шийдвэр гаргах.

**7.4. Аврагч:**

7.4.1. эрэн хайх, аврах ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх;

7.4.2. эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж түүнийг зориулалтын дагуу эзэмших;

7.4.3. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, аюул тулгарсан үед тусlamж үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

7.4.4. эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр тухайн орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын иргэдийг хариуцан эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах;

7.4.5. эрэн хайх, аврах ажиллагааны явцад нэрвэгдэгсэд болон буцалтгүй нэрвэгдэгч /цогцос/-ийн мэдээллийг задруулах, хүндэтгэлгүй, ёс бус харьцах, хувийн зорилгоор дуу хураагуур, гэрэл зураг, дурс бичлэг хийхгүй байх;

7.4.6. эрэн хайх, аврах ажиллагааны талаарх мэдээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд удирдлагын зөвшөөрөлгүй байршуулах, мэдээлэл өгөхгүй байх.

**8. Эрэн хайх, аврах ажиллагааны зохион байгуулалт**

**8.1.** Ослын мэдээлэл, дуудлагын дагуу газар орон дээр хүрэлцэн очсон эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь мэдээлэл /осол болсон цэг, магадлал бүхий чиглэл, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгсэл, харилцан ажиллагаа/ цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулна;

**8.2.** Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нь байгалийн гаралтай аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын голомтод ажиллах дараалал, төлөвлөгөө, үүрэг, аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг бүрэлдэхүүнд танилцуулна;

**8.3.** Ослын голомтод хүн байх магадлал бүхий мэдээллийг цуглуулна;

**8.4.** Эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэж буй аврагч нь тогтоосон цагт ажиллагааны явцыг удирдагчид тогтмол мэдээлэх, үүссэн нөхцөл байдлын талаар танилцуулж чиглэл авна;

**8.5.** Эрэн хайх, аврах бүлэг нь 2 хэсэг хуваагдаж ажиллах үед эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр туршлагатай мэргэшсэн аврагч нэг хэсгийг удирдана;

**8.6.** Хүч нэмэгдүүлж ирсэн аврах бүлэг, анги, салбарын захирагч болон эрх бүхий албан тушаалтан удирдлагыг албан ёсоор шилжүүлэн аваагүй тохиолдолд эхний булгийн дарга эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч байна;

**8.7.** Ослын шинж байдал нь гадны нөлөөтэй, гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй тохиолдолд хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллагын оролцоотойгоор ажиллагааг гүйцэтгэнэ;

**8.8.** Аварсан, осолдсон нэрвэгдэгчийг хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллага /амьд, бэртэж гэмтээгүй үед ар гэрт болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд/-д шилжүүлэн өгнө;

**8.9.** Аюултай эсхүл хүндрэлтэй нөхцлийн үед эрэн хайх, аврах ажиллагааг түр зогсооно;

**8.10.** Хаана, хэн, юу осолдсон нь тодорхойгүй болон нотлогдоогүй мэдээллээр эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхгүй.

## **9. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах хүч хэрэгсэл**

- 9.1.** Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Үндэсний аврах бригад, 2 ба түүнээс дээш бүсийн хүч хэрэгслийг;
- 9.2.** Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшигийн шуурхай удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга Үндэсний аврах бригадын салбар, 2 хүртэлх бүсийн төвийн Онцгой байдлын хүч хэрэгслийг;
- 9.3.** Бүсийн төвийн захирагч өөрийн бүсэд харьялгаддаг аймгуудын Онцгой байдлын байгууллагын хүч хэрэгслийг;
- 9.4.** Орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга өөрийн харьяны хүч хэрэгслийг;
- 9.5.** Эрэн хайх, аврах ангийн захирагч 4 бүлгийн хүч хэрэгслийг;
- 9.6.** Эрэн хайх, аврах салбарын захирагч 2 бүлгийн хүч хэрэгслийг тус тус дайчлан гаргана.

## **10. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах хугацаа**

- 10.1.** Эрэн хайх, аврах ажиллагааны эхний 72 цагийн хангарт /хүнс, шатахуун, багаж хэрэгсэл/-ыг тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллага хариуцна;
- 10.2.** Аврах бүлгийг сэлгэх эсхүл дэмжлэгээр ирж байгаа аврах бүлэг нь 72 цаг бие даан үүрэг гүйцэтгэх чадамжтай байна;
- 10.3.** Эрэн хайх, аврах ажиллагааг эхэлсэн цагаас хойш 144 цаг буюу 6 дахь хоногоос эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, ахлах удирдагчтай;
  - 216 цаг буюу 9 дэх хоногоос ахлах удирдагч, ерөнхий удирдагчтай;
  - 288 цаг буюу 12 дахь хоногоос ерөнхий удирдагч бүсийн төвийн захирагчтай;
  - 360 цаг буюу 15 дахь хоногоос бүсийн төвийн захирагч, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшигийн шуурхай удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргатай;
  - 432 цаг буюу 18 дахь хоногоос онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн үргэлжлэх хугацааг тогтооно.
- 10.4.** Аюулт үзэгдэл, ослын төрөл, байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 10.3-т заасан хугацааг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн саналыг үндэслэн өөрчилж болох бөгөөд шийдвэрлэх албан тушаалтны дараалал өөрчлөгдөхгүй.
- 10.5.** Эрэн хайх, аврах ажиллагааг сэргээх болон үргэлжлүүлэх тухай ар гэрийнхэн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнаас /бичгээр/ ирүүлсэн хүсэлтийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

**ТӨГСӨВ.**